


Аюулгүй ажиллагааг эрхэтлэж, байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи ашиглан ЦЭХ-ийг
найдвартай, үр ашигтай дамжуулах нь бидний эрхэн зорилго мөн.



ДАМЖУУЛАХ

Сүлжээ



2005 оноос эрхлэн гаргав.

ЦДҮС ТӨХК-ИЙН ХЭВЛЭЛ
www.transco.mn

ЁДОНДОГ МОНГОЛ УЛСЫН АЖ ҮЙЛДВЭРИЙН ГАВЬЯАТ АЖИЛТАН ЦОЛООР ШАГНАГДЛАА

№3 (161) 2024



“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн Төвийн бүсийн салбарын ахмад ажилтан, зөвлөх инженер Ёндонгийн Дондог Монгол улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цолоор шагнагдаж, төр түмэндээ хөдөлмөр зүтгэлээ үнэлүүлээ.

1966 онд Монгол улсын их сургуулийг цахилгааны инженер мэргэжлээр дүүргэж, 1999 онд техникийн ухааны магистрын зэрэг хамгаалж, 2001 онд Монгол улсын Зөвлөх инженер болсон юм.

1966-1989 онд Дархан-Сэлэнгийн цахилгаан шугам сүлжээний газрын Реле хамгаалалт, автоматикийн инженерээр 23 жил,

1989-1993 онд ерөнхий инженерээр,

1993-1997 онд салбарын даргаар,

1997-2001 онд инженерийн албаны даргаар,

2001-2007 онд “Цахилгаан дамжуулах

үндэсний сүлжээ” ТӨХК-ийн Төвийн бүсийн салбарт инженерийн хэсгийн ахлах инженерээр ажиллаж байгаад 2007 онд өндөр насны тэтгэвэрт гарсан.

2007-2008 онд ШУТИС-ийн “Дархан” салбарын Эрчим хүчний тэнхимийн реле хамгаалалт, автоматикийн багш,

2008-2009 онд “Дархан” Олон улсын худалдааны төвийн цахилгаан хариуцсан зөвлөх инженер,

2010-2011 онд Улиастайн цахилгаан станцыг хүлээн авах үед зөвлөх инженер,

2011 онд Төвийн бүсийн салбарт зөвлөх инженерээр тус тус ажиллаж байсан,

Ёндонгийн Дондог нь Эрчим хүчний салбарт амьдралынхаа 40 гаруй жилийг зориулсан шилдэг инженер юм.

АЛТАН ГАДАС, ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР ШАГНУУЛЛАА



Зүүн гар талаас Ж.Батцэнгэл,
Б.Дашдаваа, Б.Мөнхжаргал, А.Төмөртоого

Шинэ оны босгон дээр Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн төрийн дээд одон медаль хүртсэн ажилтнуудыг хүлээн авч, шагнал гардуулсан юм. Компанийн хамт олон дундаас Тээвэр механизмын хэлтсийн суудлын автомашины жолооч Ж.Батцэнгэл “Алтан гадас” одонгоор, Тээвэр механизмын хэлтсийн дарга Б.Мөнхжаргал, мөн хэлтсийн ачааны автомашины жолооч А.Төмөртоого нар “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар шагнуулж, ажил хөдөлмөрөө үнэлүүлэв. Компанийн удирдлага хамт олны зүгээс ажилтнуудад хүндэтгэл үзүүлэн баяр хүргэж, ажил хөдөлмөрийн өндөр амжилтыг хүслээ.

НҮҮР-3

КОМПАНИЙН
2024 ОНЫ
АВАРГУУД

НҮҮР-5

УЛААНБААТАР САЛБАР

НҮҮР-7


ХАНГАЙН БҮСИЙН
САЛБАР

НҮҮР-9

ГОВИЙН БҮСИЙН
САЛБАР

НҮҮР-11

"ЦАХИЛГААН
ДАМЖУУЛАХ
ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ"
ТӨХК-ИЙН 2024 ОНЫ
ШИЛДЭГ 10 АЖИЛ



ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН РЕФОРМ

Шинэ Засгийн газар байгуулагдаад 34 жил гацаанд байсан “Эрчим хүчний салбарын реформ”-ыг сэргээж, 2024 оны 10 дугаар сард “Эрчим хүчний үндэсний хороо” байгуулсан. Хорооны даргаар УИХ гишүүн, Шадар сайд Х.Доржханд, хорооны гишүүнээр эрчим хүчний салбараас УИХ-д сонгогдсон М.Энхцэцэг гишүүн томилогдон ажиллаж байна. Реформын хүрээнд Эрчим хүчний тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай, Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулиуд болон холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг байгуулж, манай компаниас ТБТХ-ийн техникийн шинэчлэл хариуцсан инженер П.Ариунболд, ХМХ-ийн Санхүүгийн дотоод хяналтын мэргэжилтэн Н.Үүрцайх нар ажиллаж байна. “Алсын хараа-2050” бодлогын хүрээнд салбар дундын уялдааг хангах үүрэг бүхий “Эрчим хүчний асуудал хариуцсан дэд хороо”-ны бүрэлдэхүүн 2024 оны 09 дүгээр сарын 06-нд манай компанийн үйл ажиллагаатай танилцаж, эрчим хүчний реформын тухай, эрчим хүчний хуулийн шинэчлэлийн ажлын талаар ярилцаж, санал бодлоо солилцсон юм.



Зүүн гар талаас Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, УИХ-ын гишүүн М.Энхцэцэг, Шадар сайд Х.Доржханд, УИХ-ын гишүүн Б.Найдалаа

Эрчим хүчний зохицуулах хороо нь шинэчлэлийн хүрээнд эрчим хүчний үнэ тарифын шинэчлэлийг үе шаттай нэмэгдүүлэхээр болсон бөгөөд 2024 оны 11 дүгээр сард

Айл өрхийн эхний 150 кВт/цаг хүртэлх хэрэглээг 175 төг 150-300 кВт бол 256 төгрөг

300 кВт бол 285 төгрөг

ААН-ийн цахилгааны хэрэглээг 280 төгрөг болгож батласан юм.



АЖИЛЛАНГАА СУРАЛЦАХ БОЛОМЖТОЙ ХОСМОГ СУРГАЛТЫГ ЭХЛҮҮЛЛЭЭ

Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)-ээс МУ-д “Монгол Улсын тогтвортой эрчим хүчний чадавхыг бэхжүүлэх”, “Түншлэлд суурилсан техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт-2” төслүүдийг хэрэгжүүлж байгаа бөгөөд уг төслийн хүрээнд “Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрүүдийг төвийн бүсийн түгээх, дамжуулах сүлжээнд холбох үр чадвар бүхий өндөр хүчдэлийн техникч мэргэжлийн практикт суурилсан хосмог сургалтын хөтөлбөрийг боловсруулж, цаашид энэ чиглэлийн мэргэжилтэй ажилтныг ажил олгогч байгууллагуудтай хамтран бэлтгэх” зорилтыг GIZ, ЭХЯ, БСШУЯ зэрэг талууд хамтран хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Хосмог сургалтын хөтөлбөрийн дагуу онолын ухагдахууныг Налайх дүүрэг дэх Политехник коллеж болон Дархан-Уул аймаг дахь Дархан политехник коллежд, мэргэжлийн үр чадвар олгох үйлдвэрлэлийн дадлагын үйл ажиллагааг “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК дээр тус тус хэрэгжүүлэхээр болж 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдөр “Монгол улсын тогтвортой эрчим хүчний чадавхыг хөгжүүлэх төсөл” болон “Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ” ТӨХК-ийн хооронд Харилцан ойлголцлын санамж бичигт хоёр тал гарын үсэг зурсан юм.

Хосмог сургалтыг 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрөөс Налайх дүүрэг дэх Политехникийн коллеж болон Дархан-Уул аймаг дахь Политехникийн коллеж дээр эхлүүлж компаниас нийт 37 ажилтан суралцаж байна. Нээлтийн үйл ажиллагааг Налайх дахь Политехникийн коллеж дээр 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулжээ.



220 КВ-ЫН ЗЭС-ОЮУ ДЭД СТАНЦ, ЦДАШ-ЫН БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ ХИЙГДЭЖ БАЙНА.


“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК нь Оюутолгой ХХК-тай байгуулсан 2024/110 дугаар гэрээний дагуу 220 кВ-ын Зэс-Оюу сэлгэн залгах дэд станц, 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын барилга угсралтын ажлыг эхлүүлээд байна. Тус ажлыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд компанийн 100 орчим ажиллах хүчний нөөцийг бүрдүүлж, Оюутолгой ХХК-ийн аюулгүй ажиллагааны шаардлагын дагуу 34 нэр төрлийн сургалтад хамруулж, 10 ширхэг тусгай зориулалтын машин механизмыг бүрэн тоноглож, төслийн талбай дээр ажил гүйцэтгэх нөхцөл шаардлагыг бүрэн хангасан. Эхний ээлжинд анхдагч хэлхээний тоноглолыг угсарч суурилуулах ажилд 50 орчим ажилтан 2 ээлжээр хуваарь гарган дараах ажлуудыг гүйцэтгэж байна Үүнд:

Ил хуваарилах байгууламжийн барилга угсралтын ажлын талбайг 3 хэсэгт хуваан ажил гүйцэтгэж одоогийн байдлаар В, С хэсгийн суурийн ухлага, бетон суурь цутгалт болон нягтруулгын ажил дуусах шатандаа орж, үндсэн тоноглол угсарч суурилуулах ажлыг үе шаттай суурилуулж эхлээд байна.

Уг ажлын эзлэхүүнд буй 220 кВ-ын Хятад-А, Б ЦДАШ-ын 3 ширхэг тулгуур угсрах ажлын хүрээнд улаан шугам тавьж суурийн ухлага малталт хийх, фундамент суурилуулах ажил үргэлжлэн хийгдэж байна.

2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар 220/110/35 кВ-ын Оюутолгой дэд станцаас 220 кВ-ын гаргалгаагаар Зэс-Оюу дэд станцтай холбогдох ЦДАШ-ын угсралтын ажил гүйцэтгэж 90 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна.





КОМПАНИЙН 2024 ОНЫ АВАРГУУД

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК 2024 оноо үдэж, эзэмшсэн мэргэжилдээ эзэн нь байж ажил хөдөлмөрөөрөө хамт олноо манлайлсан хөдөлмөрийн аварга, тэргүүний ажилчдаа тодруулж урамшууллаа.



ХӨДӨЛМӨРИЙН АВАРГА
УДИРДАХ АЛБАН ТУШААЛТАН
Н.БЯМБАДОРЖ (ГБС-ЫН ДАРГА)



ХӨДӨЛМӨРИЙН АВАРГА
ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН АЖИЛТАН
М.НОРОВСАМБУУ (ТБС ӨНДӨР ХҮЧДЛИЙН
ТУРШИЛТ ХЭМЖИЛТИЙН ИНЖЕНЕР)



ХӨДӨЛМӨРИЙН АВАРГА
ШУУРХАЙ АЖИЛЛАГААНЫ ИНЖЕНЕР
ТЕХНИКИЙН АЖИЛТАН Ё.АЛТАНГЭРЭЛ
УБС-ЫН ЭЭЛЖИЙН ИНЖЕНЕР)



ХӨДӨЛМӨРИЙН АВАРГА АШИГЛАЛТЫН
МОНТЁР Б.МӨНХЖАРГАЛ (ЗӨБС-ЫН
ЭЭЛЖИЙН МОНТЁР)



ХӨДӨЛМӨРИЙН АВАРГА
ЗАСВАРЫН МОНТЁР Ч.ЦООДОЛ
(ХБС-ЫН ЗАСВАРЫН МОНТЁР)



ХӨДӨЛМӨРИЙН АВАРГА АЛБАН ХААГЧ
Б.ГАНЦЭЦЭГ (ТӨВ УДИРДЛАГА-АХЛАХ
ЭДИЙН ЗАСАГЧ)



ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН Б.ОТГОНТӨГС
(ТӨВ УДИРДЛАГА-АХЛАХ
ТОГООЧ)



ХӨДӨЛМӨРИЙН АВАРГА АЖИЛТАН
Д.ТҮВШИНБААТАР (ГБС-ТУСГАЙ
ЗОРИУЛАЛТЫН МАШИН МЕХАНИЗМЫН
ЖОЛООЧ)


Ажлын байрны соёл-5С хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн 2024 оны “Шилдэг дэд станц” дараах дэд станцууд шалгарсан байна.



ТЭРГҮҮН БАЙР ХАНГАЙН БҮСИЙН САЛБАРЫН
110/35/10 КВ-ЫН “БУЛГАН ДЭД СТАНЦ”



ХОЁРДУГААР БАЙР-ЗҮҮН-ӨМНӨД БҮСИЙН САЛБАР
220/110/35 КВ-ЫН “БАГАНУУР ДЭД СТАНЦ”



ГУРАВДУГААР
БАЙР-
УЛААНБААТАР
САЛБАРЫН
110/10/6 КВ-ЫН
“ДУНДГОЛ ДЭД
СТАНЦ”

ТЕСЛА БА ЭДИСОН УРАЛДААНЫ ШИЛДЭГҮҮД ТОДРОВ

Ажилтнуудын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, оновчтой санал, бүтээлийг дэмжиж урамшуулах шинээр дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх зорилготой “Тесла ба Эдисон” уралдааныг 2020 оноос хойш зохион байгуулсан бөгөөд энэ жил уг уралдаанд дараах багууд шалгарсан байна.

“ШИЛДЭГ БҮТЭЭЛ” ТӨРӨЛ

“Бие даасан нумын реле”-г зохион бүтээсэн Улаанбаатар салбарын Реле хамгаалалт, автоматик, хэмжилт, туршилтын албаны ахлах инженер Д.Төмөр-Очир удирдагчтай баг

Дамжуулах сүлжээний дотоод хэрэгцээний алдагдлыг бууруулахад дэд станцын гэрэлтүүлгийн хэрэглээг бууруулах арга зам судалгааг хийсэн Улаанбаатар салбарын Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны диспетчер инженер Б.Даваасамбуу, Э.Сосорбарам

“Бие даасан нумын реле”-г зохион бүтээсэн Улаанбаатар салбарын Реле хамгаалалт, автоматик, хэмжилт, туршилтын албаны ахлах инженер Д.Төмөр-Очир удирдагчтай баг



Д.ТӨМӨР-ОЧИР



Э.СОСОРБАРАМ



Б.ДАВААСАМБУУ



Ч.СУГИРТОГТОХ

“ШИЛДЭГ ТӨСӨЛ” ТӨРӨЛД



Б.БУЯННЭМЭХ

“Конденсатын нөлөөгөөр үүсэх мөсжилт чийгшлээс сэргийлэх агааржуулалтын тор”-ыг санаачилан бүтээсэн Улаанбаатар салбарын Засварын албаны дэд станцын засварын мастер Б.Буяннэмэх дэд байр



Б.СЭРГЭЛЭНБААТАР



Б.ШИНЭСАЙХАН

“Автотрансформаторын хөргөлтийн насосны монаметр” төслийг боловсруулсан Хангайн бүсийн салбарын засварын монтер Б.Сэргэлэнбаатар, засварын монтер Б.Шинэсайхан нарын баг дэд байр

ХАБЭА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Олон улсын стандарт хэрэгжүүлэх сургалтад хамрагдав

Байгууллагын үйл ажиллагаанд хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын MNS ISO45001:2018 менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх зорилгоор Обзерв консалтинг ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, тус стандартыг төв удирдлага болон Улаанбаатар салбарт төслийн багийг гүйцэтгэх захирлын тушаалаар томилж, зөвлөх үйлчилгээний багтай хамтарсан баг ажиллаж эхэлсэн. Төслийн ажил 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн одоог хүртэл үргэлжилж байна.



Төслийн хүрээнд “Обзерв консалтинг” ХХК-ийн зөвлөхүүдтэй хамтран нийт ажилтнуудад 4 удаагийн, төслийн үндсэн багийн гишүүдэд 12 удаагийн сургалт зохион байгуулсан.

Төслийн үндсэн багуудаас Улаанбаатар салбарын 14 ажилтан дотоод аудитын сургалтад хамрагдаж, “Дотоод аудитор”-ын гэрчилгээ авсан үр өгөөжтэй сургалт болсон юм. Төслийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. ХЭМАБМТ-ны хүрээнд 36 үйл явцыг нэрлэж, үүнээс шинээр 12 процесс (үйл явц)-ын зураглал зурж, бусад үйл явцыг нь журмаар зохицуулсан. Нийт 36 үйл явцын

шинэ 10, сайжруулсан 8, хуучин 18 журам байна

2.Төв удирдлага болон Улаанбаатар салбарын нийт 98 ажлын байранд ХАБЭА-н эрсдэлийн үнэлгээ хийсэн.

3.Нийт ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгаагаар “Аюулыг мэдээлэх хуудас”-ыг цахим болгох зүйтэй гэж ихэнх ажилтнууд санал өгсний дагуу аюулыг мэдээлэх тогтолцоог ДСУМС программтай холбох талаар 2024 оны 09 дүгээр сард “Өнө тэгш” ХХК-д хүсэлт, санал хүргүүлсэн.

4.Нийт 45 ажлын байранд зааварчилгааг сайжруулж, шинээр бий болгосон.

5.Ажлын байрны ХАБЭА-н I, II шатны үзлэгийн хуудсыг нэгжийн үйл ажиллагааны онцлогт тохируулан бий болгох ажлыг эхлүүлсэн.

6.Компанийн ХАБЭА-н үйл ажиллагааны төлөвлөгөөг стандарт шаардлагад нийцүүлэн OGSM загвараар боловсруулж батлуулсан.

7.ХАБЭА-н зардлыг хуульд заасны дагуу төлөвлөдөг болсон.

8.Хөдөлмөрийн сайдын А/173 дугаар тушаалын дагуу ХАБЭА-н сургалтыг бүрэн төлөвлөдөг болсон.

Сургалт зохион байгуулав

ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны санхүүжилттэй GIZ төсөлтэй хийсэн хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд шат дараатай сургалтуудад ажилтнуудыг хамруулж, Монгол Улсад анх удаа “Ажлын байрны хосмог” сургалтыг Налайхын политехник коллежтой хамтран хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн. “Ажлын байрны хосмог” сургалт 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн Улаанбаатар салбараас 8 ажилтан хамрагдаж байна. Мөн 110/35/10 кВ-ын Туул дэд станцын ОРУ-д GIZ төслийн санхүүжилттэйгээр өндөр хүчдэлийн сургалтын полигон барих бэлтгэл ажлыг эхлүүлсэн.



ЭХҮТ ТӨХХК-ийн сургалт үйлдвэрлэлийн төвд 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулагдсан сагст өргөгч болон хайчин өргөгчийн сургалтад ЗА, АШҮА, РХАХТА-ны 5 ажилтныг хамруулсан.



Батлагдсан хөтөлбөрийн дагуу “Шинэ ажилтны ажлын байрны сургалт”-ыг 2024.12.24-ний өдөр салбарын сургалтын танхимд, ажлын байрны сургалтыг 2024.12.25, 26-ны өдрүүдэд Туул дэд станц дээр тус тус зохион байгуулсан.



“Хөдөлмөрийн аюулгүй байдлын өдөр”-өөр Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газрын ахмад Л.Эрхэмбаяр, мөрдөгч Мөнхнаран нараар цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон авлигын гэмт хэргийн талаар сургалт заасан.



Дэд станц, ЦДАШ-ын координатын цэг тодорхойлох ажил гүйцэтгэв.

Өнө тэгш ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулсны дагуу 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Injenering geodesie LLC-CHH target багажийн сургалт авч, ажил эхэлсэн. Нийт 34 дэд станцаас өөрийн эзэмшлийн газартай 31 дэд станцын цэг тодорхойлох

ажил хийгдсэн. 220 кВ-ын нийт 292 км 9 шугам, 110 кВ-ын 504 км 43 шугам, 35 кВ-ын 7,5 км 3 шугам нийт 804 км ЦДАШ-ын цэг тодорхойлох ажил хийгдэж, 117, 118, 208, 209, 210, 213, 214 дүгээр АШ-ын цэг тодорхойлох ажлыг 18 хоног албан томилолтоор ажиллаж, шатахууны зардлыг хэмнэсэн.



Координатын цэг тодорхойлох ажлыг хийснээр компанийн хөрөнгөө, цаг хугацаа хэмнэхээс гадна Засварын албаны хувьд шугам, тулгуур бүрээр мэдээллийн сангийн баяжилт тогтмол шинэчлэх, харах, мэдээлэл авах, инженерүүдийн хувьд тодруулга гаргахад заавал газар дээр нь очих шаардлагагүй тухайн программаас харах, хамгаалалтын зурвасын зөрчлийг бодитоор харах албан мэдэгдлийг цаг алдалгүй өгөх боломж бүрдэж байна.

АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

Улаанбаатар салбарын Засварын алба 18 ажилтны бүрэлдэхүүнтэй 2 ростор ажиллуулж, Оюутолгойн уурхайн төслийн талбайд ажилтнуудыг сургалтад хамруулах, ажил эхлүүлэх PRE-JOB CHECK LIST-н дагуу бичиг баримт боловсруулах, Оюутолгой ХХК-ийн төслийн багтай хамтран хэлэлцэж, шаардлагатай бичиг баримт сайжруулах, ажилтнуудын түр кемп байгуулах ажлуудыг зохион байгуулж, холбогдох хүмүүстэй хамгарч ажиллаж байна.

• 11 тулгуурын 44 ширхэг суурийн нүх экскаватороор ухах, суурийн нүхэнд гараар тэгшилгээ хийх, ул бэлтгэх, Ф5А, Ф4-2 маркийн фундамент 44 ширхэг суурилуулж буцаан булах, облом, машин

механизм зогсох талбай засах


- У220-2Т (+9) маркийн анкер тулгуур 2 ширхэг, У220-2Т маркийн анкер тулгуур 2 ширхэг, дундын ПС220-2 маркийн тулгуур 3 ширхэг, П220-2Т маркийн тулгуур 4 ширхэг, нийт 11 ширхэг төмөр тулгуур угсрах, чангалгаа хийх, босгох
- Шугамын порталаас тулгуур №1-р анкер тулгуур хүртэл АС-300/39 маркийн дамжуулагч утсыг сунгах, татах, бэхэлгээ хийх
- Хуучин трассаас буусан У220-2Т маркийн анкер тулгуурыг 2 ширхэг шинэ трассад шилжүүлэн байрлуулах, ПС220-2Т маркийн төмөр тулгуурыг 3 ширхэг хуучин трассаас шинэ трасс руу

шилжүүлэн байрлуулах

- ПС220-2Т маркийн 1 ширхэг төмөр тулгуурыг буулгаж Оюутолгой дэд станцын хашаанд буулгах, хуучин дамжуулагч АС-330/39 маркийн утас хураах ажлууд хийгдсэн байна.


110/10 кВ-ын Дулаан дэд станцад 2024 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 17 цаг 33 минутад Т-2 трансформатор хамгаалалтаар тасарч, 10 кВ-ын гүүрэн шинийн хайрцагт цан үүсэж 5 ширхэг тулгуур изолятор гэмтсэн ноцтой гэмтэл гарсан. Гэмтлийн шалтгааныг дэд станцын засварын мастер Б.Буяннэмэх Т-1, 2 трансформаторын 10 кВ-ын гадна болон дотор гүүрэн шинийн хайрцагт агаар сэлгэх систем байхгүй

улмаас цан үүсэж тулгуур изолятор нэвт цохигдон гэмтэл үүсгэсэн үйлдвэрлэгчийн алдааг мэргэжлийн ур чадвар гарган илрүүлж, өөрийн санаачилгаар Т-1, 2 трансформаторын 10 кВ-ын дотор болон гадна гүүрэн шинийн хайрцагт конденсацийн нөлөөгөөр үүсэх мөсжилт чийгшлээс сэргийлэх агааржуулалтын тор санаачлан хийсэн нь цаашид 110/10 кВ-ын Дулаан дэд станцын найдвартай ажиллагааг хангах, гэмтэл давтан гарах, цаашилбал трансформатор болон бусад тоног төхөөрөмжүүдийг гэмтээх, их хэмжээний зардлын хохирол гарах зэрэг эрсдэлүүдийг бүрэн шийдсэн, цаг үеэ олсон үр дүнтэй, бүтээлч шинэ санаа болсон юм.



ТӨВИЙН БҮСИЙН САЛБАР

ХАБЭА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ



2024 оны Төвийн бүсийн салбарын ээлжит шалгалтын батлагдсан удирдамжийн дагуу 2024 оны IV улирлын ХАБЭА-н III шатны үзлэгийг салбарын харьяа 13 дэд станцад хийсэн. 2024 онд 26 ажлын байранд ХАБЭА-н III шатны үзлэг хийж ажлын тайланг нэгтгэн салбарын удирдлагад танилцуулан одоогоор 80 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна.



Салбарын ээлжит сургалтыг 2024 оны 11, 12 дугаар саруудад зохион байгуулсан бөгөөд сургалтыг тэнхим болон цахим хэлбэрээр явуулж салбарын нийт 209 ажилтан хамрагдсан. Ээлжит шалгалтын удирдамжийг гарган батлуулсан.

Галын дүгнэлт

Салбарын хэмжээнд харьяа 20 объектод галын дүгнэлтийн хугацаа дууссан байсан бөгөөд Дархан-Уул аймаг, Сэлэнгэ, Төв

аймгийн онцгой байдлын газаруудтай хамтран Сэлэнгэ аймгийн харьяа 6 дэд станц, Төв аймгийн харьяа 2 дэд станц, Дархан-Уул аймгийн 6 дэд станцад галын дүгнэлт гаргуулж ажилласан байна.



Салбарын ажилчдын албаны бэлтгэл бэлэн байдал, ой хээрийн гал түймрийн багаж хэрэгсэлийг шалгах ажлын удирдамжийн хүрээнд салбарын гал эсэргүүцэх дасгал ажлыг 2024 оны 11 дүгээр сарын 16-ны Дархан-Уул аймаг дахь гал командын 22 дугаар ангитай хамтран зохион байгууллаа.



Төвийн бүсийн Салбарын нийт 56 ажилтан бэлэн цугларч ажлын хувцас бүрэн өмссөн эсэх, аранзны бэлэн байдал машин техник, галын багаж хэрэгсэл

зэргийг газар дээр нь шалгасан бөгөөд мөн ой хээрийн түймэр унтраах арга барил, өөрийгөө болон бусдыг аврах сургуулилт, дадлага хийж дүгнэлт гарган ажилласан.

2024 оны 10, 11 дүгээр сард шинээр ажилд орсон 10 ажилтанд урьдчилсан зааварчилгаа өгч, ажлын байр өөрчлөгдсөн 12 ажилтнаас ээлжит бус шалгалт авах ажлыг зохион байгуулсан.



Компанийн хэмжээнд ISO 45001 ХЭМАБ-ын менежментийн тогтолцоо нэвтрүүлэх ажлын хүрээнд манай салбарын харьяа 4 станцын бүтэц зохион байгуулалттай танилцаж, зөрүүгийн шинжилгээ хийж, тайланг 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдөр танилцуулан ажлын төлөвлөгөө гарган зохион байгуулалтад орж ажиллаж байна.

АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

А. ТӨЛӨВЛӨГӨӨТ АЖИЛ:

1. Графикийн дагуу Тосгон, Бугант Толгойт, Сүхбаатар, Шарын гол, Орхон дэд станцуудын анхдагч тоноглолуудад үзлэг хийж ОД, КЗ-ийн ажиллагааг шалгасан. Мөн өвлийн бэлтгэл ажлын хүрээнд трансформаторын тосны түвшинг тохируулан цаашид нөөцөд байх шаардлагатай тосыг дээрх станцууд 11 дүгээр сарын 18-22-ны өдрүүдэд байршуулсан.



Б. АГААРЫН ШУГАМЫН ЭРГҮҮЛ ҮЗЛЭГ

110 кВ-ын Хөтөл А, Б, Орхон, Ерөө-Бугант, Баясгалант, 114, 115, 116, 220 кВ-ын 201, 202, 208 дугаар агаарын шугамуудын

нийт уртад ээлжит үзлэг хийсэн. Үзлэгээр 114 дүгээр АШ-д 8 тулгуурт шувууны үүртэй, 116 дугаар АШ-д 2 элемент нэвт цохигдсон, Баясгалант АШ-д 3 тулгуурт шувууны үүртэй, 2 элемент хагархай, 5 тулгуурт чимээ намжаагч унасан, 2 тулгуур газардлага ил гарсан, судал тасарсан, Хөтөл АШ-д 3 тулгуурт элемент хагархай зэрэг гэмтэл зөрчлүүд илэрсэн. Илэрсэн гэмтэл зөрчлийг устгах ажлыг хийж гүйцэтгэсэн.

В. ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС АЖИЛ БОЛОН ГЭМТЭЛ УСТГАЛТЫН АЖИЛ

1. 110 кВ-ын Сүхбаатар агаарын шугамын тасралтын зоонд Т№200-288 хооронд ээлжит бус үзлэг хийсэн. Үзлэгээр Т№ 140-ийн В фазын нэвт цохигдсон элемент сольсон.

2. 110 кВ-ын 116 дугаар агаарын шугамын Т№ 30-100, 220 кВ-ын 208 дугаар агаарын шугамын Т№ 210-216, 230-270 хооронд тасралтын дараах ээлжит бус үзлэг хийсэн. Үзлэгээр 116 дугаар шугамын Т№42, 43, 44 тус бүр 1 элемент хагархай, АТ№ 106 шлефний 1 судал тасарсан, 208 дугаар шугамын Т№255, 278 элемент хагархай, нэвт цохигдсон гэмтэл зөрчлүүд илэрсэн.



Цаг үеийн ажлын талаар

Салбарын 60 жилийн ойг угтан нийт албан хаагч, ажилтнуудын дунд дамжуулах сүлжээний найдвартай ажиллагааг дээшлүүлэх, ашиглалтын үед тулгарч буй хүндрэлүүд, түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох, салбарын үйл ажиллагааны өнөөгийн байдлыг дүгнэх, хэтийн төлөвийг тодорхойлох, орчин үеийн дэвшилтэт технологийн талаар мэдээлэл солилцох, ажилтнуудын мэдлэг чадварыг хөгжүүлэх, санал санаачилгыг дэмжих, олон талт байр



суурь, үзэл бодлыг сонсож хэлэлцүүлэг өрнүүлэх зорилготой "Цахилгаан эрчим хүч, дамжуулалтын найдвартай ажиллагаа" сэдэвт онол практикийн бага хурлыг 2024 оны 08 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан.

Гүйцэтгэх захирлын А/210 дугаар тушаалаар зохион байгуулагдсан "РХА-ийн монтерын" Чадамжийн гэрчилгээ олгох 80 цагийн сургалт 2024 оны 12 дугаар сарын 09-18-ны өдрүүдэд Төвийн бүсийн салбарын Чадамжийн төвд зохион байгуулагдсан. Уг сургалтад 5 салбарын нийт 6 ажилтан хамрагдсан.



ХАНГАЙН БҮСИЙН САЛБАР

1. 10 МВт-ын Хөвсгөл НЦС ашиглалтад орох төслийн ажлын хүрээнд 110/35/6 кВ-ын Мөрөн дэд станцын 110 кВ-ын ИХБ-д өргөтгөл хийгдсэн. Мөн Завхан аймгийн Тосонцэнгэл суманд 30МВт чадалтай Тосон ДЦС-ын эхний блокийг ажилд залгаснаар Мөрөн-Тэлмэн чиглэлд шинэ эх үүсвэрүүд нэмэгдлээ.




2. 110 кВ Арвайхээр ЦДАШ-ын Дуутын голын намагт байрласан тулгуур №156-165-ыг шилжүүлэн, трасс өөрчлөх ажлыг хийж гүйцэтгэснээр найдвартай ажиллагаа дээшилж, шугамын үзлэг хийхэд хялбар болсон.



3. Эрдэнэт дэд станцын 220 кВ-ын 10 ком, 110 кВ-ын 8 ком хуурай салгуур солих ажил нь ТЗБАХ болон хувийн хөрөнгө оруулалтаар хийгдэн ашиглалтын түвшин дээшилж, аюулгүй ажиллагаа сайжирлаа.



4. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2022 оноос эхэлсэн 110/35/10 кВ-ын Баянхонгор дэд станцад 16 МВА-ын Т-1, 2 трансформатор, 5 МВар-ын СВГ суурилуулах өргөтгөл шинэчлэлтийн ажил бүрэн хийгдэж дууссан байна.



5. 110 кВ-ын Тэлмэн АШ-д нэмэлтээр дундын тулгуур босгох, тулгуур өөрчлөх, Хархорин-А, Б АШ-ын ТН498, 770-д анкер тулгуур босгох ажил хийгдэж, салбарын чухал ач холбогдолтой транзит шугамуудаа хүчитгэлээ.



6. Салбарын нийт ажилтнуудын дунд "Хөдөлмөрийн аюулгүй байдал-Манлайлал" сэдэвт тэмцээнийг ХАБ-ийн сарын аяны хүрээнд зохион байгуулж, 6 багийн 30 ажилтан мэдлэг оюунаа сорин өрсөлдөв.



7. Хархорин дэд станцад аваарын процесс бичигч ПАРМА төхөөрөмжийн суурилуулалт, холболт, тохируулгын ажил хийгдэж бүрэн ажилд оруулсан. Мөн дэд станцуудын ДХ-ний тоолууруудыг РИМ-489 маркийн 21 ш тоолуураар сольж, тоолуурын нэгдсэн системд холбох ажил хийгдсэн байна.



8. Салбарт ашиглагдаж буй ЗИЛ-131 МТО маркийн 2 ш тусгай зориулалтын автомашинуудын их засварын ажлын хүрээнд арын бүхээгийг засварын бригад байрлах, амрахад ая тухтай байхаар засварлан шинэчилж, Камаз Новас-460 АГП маркийн 46 метр сунах сагстай өргөгч бүхий тусгай зориулалтын автомашинаар парк шинэчлэлт хийсэн.



2024 онд тус салбарын 220/110/35/6 кВ-ын Эрдэнэт дэд станцын 50 жил, 110/35/10 кВ-ын Булган дэд станцын 40 жил, 110/35/6 кВ-ын Мөрөн дэд станц 20 жилийн ой тохиосон. Тэгш ой тохиож байгаа гурван дэд станцдаа салбарын удирдлагуудын зүгээс Монгол улсын эрчим хүчний нэгдсэн сүлжээний зургийг гардууллаа.




9. Сансар дэд станцын 10 кВ-ын ХХБ-ийн ячейкууд, Мөрөн дэд станцын Т-3 трансформаторын 6 кВ талын ашиглалтын хугацаа дуусаж, насжилт өндөртэй ячейкуудыг шинэчлэн сольж, ашиглалтын түвшинг дээшлүүлсэн.



10. Тэгш ойн жилүүдтэй аймгууд дахь Эрдэнэт, Мөрөн, Булган дэд станцуудыг хүчдэлд залгасан бөгөөд ажилчдын ажиллах ая тухтай нөхцөлийг бүрдүүлж ажлын байрны болон гадна тохижилтын ажлуудыг гүйцэтгэлээ.





ЗҮҮН-ӨМНӨД БҮСИЙН САЛБАР

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумд газрын тос дамжуулах хоолой Өргөх халаах станц-2 тэжээл, 110 кВ-ын ЦДАШ-ын 48,6 км барилга угсралтын ажлыг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс 11 дүгээр сарын 08-ны өдрийн хооронд Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн Зүүн-Өмнөд бүсийн салбар болон Төвийн бүсийн салбарын хамтарсан нийт 54 хүний бүрэлдэхүүнтэй бригад хийж гүйцэтгэсэн юм.



Нийслэлийн хөрөнгө оруулалтаар Багануур дүүрэгт баригдсан 50 МВт-н Багануур батарей хуримтлуурын станцын 163, 164 дугаар ЦДАШ, түүний холболтын тоноглолуудыг 2024 оны 11 дүгээр сарын 30-аас 12 дугаар сарын 01-ний өдрүүдэд хүчдэлд залгаж туршилтын хүчдэл дор амжилттай залгасан.



батарей хуримтлуурын станц

Хэнтий аймгийн Дадал сумын нутагт баригдах Чингис хаан аялал жуулчлалын цогцолборын цахилгаан хангамжийн багц-1 хүрээнд, 110/35/6 кВ-ын Өндөрхаан дэд станцад Т-1, 2 трансформаторын хүчин чадлыг 2х25 мВА-р нэмэгдүүлсэн мөн 110 кВ-ын ИХБ-ийн тоноглолууд шинэчлэн хүчдэлд залгасан байна.



Бөөрөлжүүт цахилгааны станцын төслийн ажлын хүрээнд 261, 262 дугаар ЦДАШ-ыг 2024 оны 07 дугаар сарын 18, 21-ний өдрүүдэд туршилтын хүчдэлд залган Бөөрөлжүүтийн системд хүлээлгэн өгсөн.



Эрчим хүчний “Жуух бичиг”-ээр Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны диспетчер инженер Д.Бямбаа, Замын-Үүд дэд станцын ээлжийн техникч Г.Бат-Энх, Өндөрхаан дэд станцын ээлжийн монтер Б.Мөнхжаргал, Реле хамгаалалт, автоматик, хэмжилт, туршилтын албаны өндөр хүчдэлийн туршилт, хэмжилтийн инженер Д.Буянболд, Айраг дэд станцын ээлжийн техникч М.Соронзонболд, Чойр хэсгийн тусгай зориулалтын автомашин механизмын жолооч Д.Уугансүх нар тус тус шагнагдлаа.



ГОВИЙН БҮСИЙН САЛБАР

ХАБЗА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ


Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах, шалгалт авах тухай Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/173 дугаар тушаалын дагуу салбарын нийт ажилтнуудын ХАБЗА-н сургалтыг 2024 оны 08 дугаар сарын 02-ны өдөр “ЭС ТИ СИ ЭС ХХК”-тай хамтран зохион байгуулж танхимаар 25 ажилтан, цахимаар 25 ажилтан сургалтад хамрагдаж сертификат болон батламжийг гардаг авсан юм.



Өмнөговь, Дундговь аймгийн онцгой байдлын газартай хамтран 2024 оны 10, 11 дүгээр саруудад салбарын хэмжээнд гал эсэргүүцэх дасгалыг зохион байгуулсан.



Салбарын удирдлагын байр нь өвлийн улиралд хувийн хэвшлийн хуучирсан, галлагаа, нүүрсний чанар муу уурын зуухнаас халаалт дулаанаа авдаг байснаас болж оффисын байр өвөлдөө хүйтэн ажилтнуудын ажиллах орчин нөхцөл хангагдахгүй байсан. Энэхүү асуудлыг шийдвэрлэж төвлөрсөн халаалтын системээс тусгаарлаж бие даасан цахилгаан халаалтын системийг суурилуулснаар ажилтнуудын ажиллах таатай орчин бүрдсэн.




АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК болон MCS ХХК-тай байгуулсан гэрээний дагуу Говийн бүс, Хангайн бүс, Төвийн бүс, Зүүн өмнөд бүсийн салбарын хамтарсан 37 хүний бүрэлдэхүүнтэй бригад 11 машин механизмтайгаар 110 кВ Нарийнсухайт-Баянхөндийн АШ-н барилга угсралтын ажлыг 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн гүйцэтгэж байна. Ажил гүйцэтгэх хугацаанд завсарын тулгуур буулгах, анкер тулгуурын материал татах, тулгуур жишиж гагнах, анкерын хөлний нүх ухах хөл суурилуулах, анкер тулгуур угсрах, босгох, тулгуурын нүх ухах босгох ажлыг хийж гүйцэтгэсэн.



2024 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн ээлжит үзлэгээр 215, 216 дугаар АШ-ын тулгуур № 106-ын гуя гулзайсан гэмтэл илэрсэн. Шалтгааныг тодруулахад 1 ширхэг суурь суулт өгсөн гэмтэл илэрсэн. 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдөр суусан хөлөнд ивээс хийж тулгуурыг тэгшлэх ажлыг гүйцэтгэсэн.

220/110/35/10 кВ-ын Тавантолгой дэд станцын АТ-1, 2-ын гэмтэлтэй цэнэг шавхагчийн 2 ширхэг тоолуурыг мЛА метр заагчтай тоолуураар шинээр сольж тавьж ашиглалтын үед цэнэг шавхагчийн нэвчилтийн гүйдлийг хянаж шалгах боломжтой болгосон.



2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн ээлжит бус үзлэгээр 216 дугаар АШ-ын 3 дугаар фазын ГВН тулгуурын шаттай

зайнд орсон гэмтэл илэрсэн. Чичиргээ намдаагчийн зайг холдуулах, скоб хасах их засварын ажлыг 2024 оны тодотгосон төлөвлөгөөнд оруулан тус оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс 11 дүгээр сарын 16-ны өдрийн хооронд 12 хүний бүрэлдэхүүнтэй 3 машин механизмтайгаар хийж гүйцэтгэсэн.

110/35/10 кВ-ын Даланзадгад дэд станцын 35 кВ-ын Далан-А, Б гаргалгааны 2 ширхэг таслуур, 2 ком ГТ, 4 ширхэг хуурай салгуур шинээр солих ажилд хоёрдогч хэлхээний холболт монтаж тавил тохиргоо реле хамгаалалтыг тавилын дагуу шалгаж, хэмжилт туршилтыг хийж, ДҮТ ТӨХХК-аас ирүүлсэн тавилын дагуу тохируулж поново Т200 багажаар гүйдэл шахаж харилцан үйлчлэлийг шалгаж ажилд залгасан.

Нүүрс дахин баяжуулах үйлдвэрийг цахилгаан эрчим хүчээр хангах ажлын хүрээнд 220/110/35/10 кВ-ын Тавантолгой дэд станцад 110 кВ-ын Сийрст-А, Б гаргалгааны хоёрдогч хэлхээний угсралт, хэмжилт туршилт, тохируулгын ажлыг хийж гүйцэтгэлээ.

220/110/35 кВ-ын Мандал дэд станцын 215 дугаар АШ-ын ӨДП-нд туршилт тохируулга хийж гэмтлийг устган үндсэн хамгаалалтыг ажилд оруулсан. Мөн 220/110/35 кВ-н Мандал дэд станцад аваарын процесс бүртгэх төхөөрөмж шинээр суурилуулсан. Уг төхөөрөмж нь аваарын үеийн бүх процессыг бүртгэн авах чадвартай. Ингэснээр аваарын бичлэгээс дүн шинжилгээ хийх цаашид авах арга хэмжээг тодорхойлох боломжийг олгож байна. Аваарын процесс бүртгэх төхөөрөмж суурилуулсан салбарын хоёрдох дэд станц боллоо.


Өмнөд бүсийн эрчим хүчний хэрэглээ хурдацтай өсөж өвлийн улиралд 110/35/10 кВ-ын Даланзадгад дэд станц нэг трансформаторын горимд ажиллах боломжгүй болсон. Иймд Өмнөговь аймгийн ЗДТГ, “Говийн хөгжил” сангаас санхүүжүүлэн 110/35/10 кВ Даланзадгад дэд станцын 2х10 МВА чадалтай трансформаторыг 2х25 МВА-аар сольж дэд станцын чадлыг 2.5 дахин нэмэгдүүлсэн. Мөн 110/35/10 кВ-

ын гүйдлийн трансформаторын чадлыг нэмэгдүүлж уг ажлаар хоёрдогчийн холболт монтаж угсралт, тавил тохиргоог шинэчилж тавил реле хамгаалалтыг шалгаж, хэмжилт туршилтын ажил хийж гүйцэтгэн ажилд залгуулсан. 25 МВА чадалтай Т-1, 2-ын үндсэн болон бэлтгэл хамгаалалтын

тавил 110 кВ-ын Даланзадгад АШ-ын бэлтгэл хамгаалалт, 35/10 кВ-ын СХТ-ын хамгаалалт, 35/10 кВ-ын гарсан шугамын реле хамгаалалтыг ДҮТ ТӨХХК-аас ирсэн 02/1080, 02/1316 дугаар албан бичгийн дагуу тавьж ажиллагааг шалгасан.

ИХ БОЛОН УРСГАЛ ЗАСВАРААР ХИЙГДСЭН АЖЛУУД

110 кВ-ын Даланзадгад АШ-ын нийт уртын дагуу тулгуурын газардуулгын эсэргүүцэл хэмжиж, нормоос өндөр гарсан 96 ширхэг тулгуурын газардуулгын эсэргүүцэл бууруулах их засварын ажил хийж ашиглалтын түвшин дээшлүүлж норм бариулсан. Мөн 225 дугаар АШ-ын нийт уртын дагуу тулгуурын газардуулгын эсэргүүцэл хэмжиж, 8 цэгт газардуулгын холболт салсан гэмтлийг засварласан



Засвар хийхийн өмнө



Засвар хийсний дараа


Уртын ээлжээр ажилладаг ажилтнуудын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр 220/110/35/10 кВ Тавантолгой дэд станцын ажилтнуудын кемпийн байранд засвар хийж гал тогооны хэсгийг шинээр барьж бүх кемпүүдийг нэгдсэн халаалтын системд холбосноос гадна ундны усны хэрэглээг хангах гүний худгийг гаргасан. Ингэснээр сум сууринаас алслагдсан байрлалтай дэд станцын ажилтнууд ахуйн хэрэглээний усаа зөөвөрлөхгүй, гал тогоондоо хоолоо хийж ундлах таатай нөхцөл бүрдсэн юм. Кемпүүдийн хуучин цахилгаан халаагууруудыг нэгдсэн усан халаагуурын системтэй болгож шинээр сольж тавьснаар агаарын хэт хуурайшилгүй эрүүл ахуйн шаардлага хангаж чадсан. 220/110/35 кВ

Оюутолгой дэд станцын гүний худагт ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулж уртын ээлжээр ажиллаж буй ажилтнууд ундны усаар хангагдах боломжтой боллоо.

Ажилтнуудын сургалтын орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр салбарын удирдлагын байрны сургалтын өрөөнд иж бүрэн засвар тохижилт хийсэн. Үүнд өрөөний ханын дуу чимээг тусгаарлах зориулалт бүхий акустик хавтан өнгөлгөө хийж, номын сан, номын санд сууж суралцах булан, цайны булан, индрийн хэсгийг шинээр хийж мөн өсгөгч микрофонтой болгосон юм. Уг засварын ажлын үр дүнд ажилтнуудад сургалт явуулахад таатай тохилог орчин бүрдсэн.



Кемпийн гал тогооны хэсэг




Засвар дууссан дараа



Кемпийн дэргэдэх гүний худаг



Нийт нутгийг хамарсан олон удаагийн давтамжтай хүчтэй шороон шуурганы улмаас 225 дугаар агаарын шугамын тулгуур №702, 703, 358, 450, 534 хөндлөн цууралт үүссэн байсныг их засварын ажлаар 12 хүний бүрэлдэхүүнтэй бригад, 4 машин механизмтай хийж гүйцэтгэсэн.



"ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ" ТӨХК-ИЙН 2024 ОНЫ ШИЛДЭГ 10 АЖИЛ

1. Төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд Цэвэрлэх, Баянхонгор, Өндөрхаан, Даланзадгад, Мөрөн дэд станцуудад өргөтгөл шинэчлэлтийг хийж, суурилагдсан хүчин чадлыг 126,3 МВА-р нэмэгдүүлсэн.




Мөрөн дэд станцын өргөтгөл



Даланзадгад дэд станц



2. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа 2050", эдийн засгийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд 300 МВт-н Бөөрөлжүүт цахилгаан станцын 220 кВ, газрын тос боловсруулах үйлдвэрийн өргөх станцын 110 кВ, Нарийнсухайт-Баянхөндий чиглэлийн 110 кВ-ын ЦДАШ-уудын барилга угсралтын ажлыг гүйцэтгэж, 50 МВт-н чадалтай Багануур "Батарей хуримтлуурын станц"-ыг эрчим хүчний нэгдсэн системд залган зүгшрүүлэлтийг хийсэн. 10 МВт-н "Хөвсгөл нарны цахилгаан станц"-ын төслийн хүрээнд 110/35/6 кВ-ын Мөрөн дэд станцын 110 кВ талын өргөтгөл, БНХАУ-аас ЦЭХ импортлох 220 кВ-ын "Зэс Оюу" хуваарилах байгууламжийн барилга угсралтын ажилд компанийн инженер техникийн ажилтнууд ур чадвараа гарган ажилласан.



Цэвэрлэх дэд станцын ажил



Даланзадгад дэд станц




Бөөрөлжүүт 261, 262 дуугаар ЦДАШ




Газрын тос дамжуулах хоолойн өргөх халаах станц-2-ын 110 кВ-ын ЦДАШ-ын барилга угсралтын ажил



3. Агаарын шугамын тасралт, саатлыг бууруулах зорилгоор 220 кВ-ын 216, 110 кВ-ын Тэлмэн, Бор-Өндөр, Арвайхээр агаарын шугамын утасны унжилтын зайг багасгах, замын давуулгуудад нэмэлт дундын тулгуур босгох, тулгууруудыг хүчитгэх зэрэг ажлыг хийж гүйцэтгэснээр утасны алслалтыг норм хэмжээнд хүргэн утасны гэмтлийг багасгаж, тасралтын тоог өмнөх оноос 20,7 хувиар бууруулсан. Ингэснээр тулгуур унах эрсдэл, гарч болзошгүй аваар саатлаас урьдчилан сэргийлж, шугамын үзлэг, үйлчилгээ, засвар хийхэд хялбар болсон.



АШ-216



5. 110/10/6 кВ-ын Өмнөд дэд станцын РХАБ-ийг ТЗБАХ-ээр иж бүрэн шинэчилж, "Nanjing nag" компанийн трансформаторын бэлтгэл хамгаалалт 2 ком, 6кВ, 10кВ-ын гарсан шугамууд, СХТ, реакторуудын нийт 57 ком реле хамгаалалт, НМІ, төв дохиоллыг иж бүрнээр сольсон.



РХАБ-ийг шинэчилсэн байдал




4. 110/10 кВ-ын Буянт-Ухаа дэд станцын 110/10 кВ-ын 40 МВА хүчний трансформаторын их засварын ажлыг хийж дуусгасан.



Буянт-ухаа дэд станцын трансформаторын засвар

6. E-zone портал ажилд нэвтрүүлэх ажлыг ТЗБАХ-ээр хийж гүйцэтгэсэн. Компанийн (SCADA) - Хэвийн горимын хяналт мэдээлэл, удирдлагын системд ашиглагдах алслагдсан болон сүлжээгүй дэд станцуудыг холбосноор нийт 72 дэд станц технологийн сүлжээнд холбогдож, шуурхай ажиллагаа болон SCADA-д холбогдох бололцоотой болсон.





Даланзадгад дэд станц

7. Компанийн цахилгаан хэмжлийн лаборатори нь MNS IEC 17025:2018 стандартын шаардлагыг хангаж, гэрчилгээ авснаар Монгол улсын эрчим хүчний анхны итгэмжлэгдсэн лабораторитой болсон.



8. Ажилтнуудын ажлын байрны тав тухтай байдлыг сайжруулах чиглэлээр Улаанбаатар салбарын лабораторийн хоёр давхар барилгыг шинээр ашиглалтад оруулж, тус салбарын Өмнөд, Туул, Баруун, Умард дэд станцуудад ариун цэврийн өрөөний асуудлыг шийдсэн.



9. ЦДАШ болон дэд станцын тоноглолын угсралт, засвар, хэмжилт туршилтын 17 нэр төрлийн ажлын аргачлал боловсруулан батлуулж, өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж эхэлсэн. - MNS ISO 45001:2018 стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлснээр компанид хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо үр нөлөөтэй хэрэгжиж буйг магадлан бататгах, менежментийн тогтолцооны процесс болон хяналтын арга хэмжээний гүйцэтгэлд мониторинг, дүн шинжилгээ хийж, үнэлэх ажлуудыг хэрэгжүүлж байна. - Хамгаалалтын зурваст хууль зөрчин аюул, эрсдэлтэй нөхцөлд үйл ажиллагааг явуулж, амьдран суудаг ААН, айл өрхөд сэрэмжлүүлэг мэдээлэл хүргүүлэн сургалт, сурталчилгааны ажлыг орон нутгийн засаг захиргааны төрийн байгууллагатай хамтран зохион байгуулж, 100 гаруй айл өрх, ААН-ийн газрыг бүрэн чөлөөлөх, нөхөн төлбөр ногдуулах, барагдуулах, мэдээллийн санд шугам, дэд станцын байршлын цэгүүдийг тусгаж ажилласан.




10. Компанийн хамт олны дундаас "Аж үйлдвэрийн гавьяат ажилтан" төрж, 2 ажилтан маань "Техникийн ухааны доктор"-ын зэрэг хамгаалсан. Сургалтын чиглэлээр гаднын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, JICA-н төслийн хүрээнд 30 ИТА-г гадаад сургалтад хамруулж, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэв. Монгол Улсын тогтвортой эрчим хүчний чадавхыг хөгжүүлэх (МУТЭХЧ) төсөл-ийн хүрээнд "Өндөр хүчдэлийн техникч" мэргэжлээр хосмог сургалт зохион байгуулах санамж бичгийг GIZ-тэй байгуулж, төслийн ажлыг эхлүүлээд байна.



SWG-4,5,6 багуудын төгсөлт



Жайка: SWG-3,4,5,6 багуудын Япон Улс дахь II Элжийн сургалт. 2024/02/25 – 2024/03/08



“НЭГЭН ЖАРНЫ ТҮҮХ”

БУЛАН

ТАЙЛБАР: Монгол Улсад цахилгаан дамжуулах сүлжээ үүсэж хөгжсөний нэгэн жарны түүхэн ой 4 жилийн дараа тохиох болно. Түүхийн үйл явцтай холбогдуулан Дамжуулах сүлжээ сонинд “НЭГЭН ЖАРНЫ ТҮҮХ” буланг Ахмадын хорооноос шинээр нээж техникийн дэвшил, түүнийг эзэмшигч хөдөлмөрийн хүмүүсийн тухай цувралаар нийтэлж байна. Бид өмнөх дугаартаа Улаанбаатар салбарын түүхэн товчооныг нийтэлсэн бол энэ удаад үргэлжлэлийг хүргэж байна.

УЛААНБААТАР САЛБАРЫН ОН ДАРААЛЛЫН ТОВЧООН (ЦУВРАЛ-8)

2017 он

Эрчим хүчний салбарын түүхт 95 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд тус салбарын үйлдвэр, компаниудын дунд үр ашгийг дээшлүүлэх, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх, салбарын норм стандартыг боловсронгуй болгох, зардал бууруулах зорилгоор зарласан “Бүтээлч аян” уралдаанд Улаанбаатар салбарын реле хамгаалалт, автоматикийн инженерүүдийн зохион бүтээсэн “Төв дохиоллын төхөөрөмж” бүтээл дэд байранд шалгарсан.

Өмнөд дэд станцад 10 болон 6 кВ бүх ячейкад орчин үеийн шилэн кабель ашигласан контактын системгүй нумын хамгаалалт суурилуулж, найдвартай ажиллагааг дээшлүүлсэн.

Монгол Улсын эрчим хүчний системд 10 МВА Нарны цахилгаан станц холбогдож, Баянчандмань дэд станцыг өргөтгөн хүчин чадлыг нэмэгдүүлж, 2*12,5 МВА, 110 кВ талын анхдагч болон хоёрдогч хэлхээний тоноглолыг бүрэн шинэчлэн транзит схемтэй болгосон.

ДЦС-4-ийн 3Т блокийг ИХБ-4-ийн 110 кВ-ын систем шинд шилжүүлэх ажлыг амжилттай гүйцэтгэсэн.

Хөшигтийн хөндийн Олон улсын Нисэх онгоцны буудлын цахилгаан хангамжийг 2 талын тэжээлтэй болгож найдваржуулах үүднээс 131, 132 дугаар агаарын шугамыг 203, 204 дүгээр агаарын шугамын тулгуур №48-49-ийн хооронд трасс доогуур зөрүүлэг хийсэн.

Байгалийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр 110 кВ-ын Булган-А, Б ЦДАШ-ын нийт 13 тулгуур унаж гэмтсэн, Хөтөл-А, Б ЦДАШ-ын 3 тулгуур унаж, 3 тулгуур хазайсан гэмтлийг устгахад Улаанбаатар салбарын инженер техникийн ажилтан, монтёрууд мэргэжлийн өндөр ур чадвар гарган хамтран ажиллаж, богино хугацаанд гэмтлийг устгаж, хэвийн схемд оруулсан.

Их тойрог 110/220 кВ-ын сүлжээнээс 110 кВ-ын 7 дугаар хороолол, Телевиз, Найрамдал, Буянт ухаа, 14 дүгээр хороолол, Зайсан, Шинэ Яармаг дэд станцууд сүлжээнд залгагдсан.

Цахилгаан дамжуулах сүлжээ үүсч хөгжсөний түүхт 50 жилийн ойг 2017 оны 07 дугаар сарын 05-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлж, Монголын үндэсний олон нийтийн радио телевизтэй хамтран “Дөрвөн бэрх” уралдаант цэнгээнт нэвтрүүлэг хийж,

Улаанбаатар салбарын “Адуучин” баг 1 дүгээр байр эзэлсэн.

2018 он

ИХБ-4-ийн 220 кВ-ын 13 ком хуучин салгуурыг шинэчилсэн.

ИХБ-3-ын шаазан изоляторыг шилэн изолятороор сольж, 110 кВ шинийн хамгаалалтыг шинэчилсэн.

Шилэн кабельд холбогдсон 8 дэд станцад төгсгөлийн төхөөрөмж суурилуулж, Улаанхуаран, Умард, Өмнөд, Баруун, Үйлдвэр дэд станцыг өндөр хурдны шилэн кабелийн сүлжээнд шинээр холбосон.

Өмнөд дэд станцын 6 кВ-ын реакторын хүчин чадлыг нэмэгдүүлж, автомат удирдлагатай, резисторын тохируулга бүхий реакторыг шинээр суурилуулсан.

Яармаг дэд станцын Т-1, 2 трансформаторын 35 кВ-ын С-35 маркийн 2 хуучин тосон таслуурыг ZW7 маркийн вакуум таслуураар сольж, найдвартай ажиллагааг хангасан.

Гео дэд станцын 0,4 кВ-ын дотоод хэрэгцээний панель шинэчилсэн.

Байгалийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас 110 кВ-ын Хархорин А, Б цахилгаан дамжуулах агаарын шугамд гарсан аваарыг устгахад Улаанбаатар салбарын инженер техникийн ажилтан, монтёрууд мэргэжлийн өндөр ур чадвар гарган хамтран ажиллаж, богино хугацаанд аваарыг устгаж, сэргээн засварласан.

ИХБ-3-т 110 кВ-ын систем шинийн хамгаалалт, 110 кВ-ын Үйлдвэр шугам, Т-1, 2 хүчний трансформатор, 35 кВ-ын Холбоо А, Б цахилгаан дамжуулах агаарын шугамын реле хамгаалалтыг иж бүрнээр шинэчилсэн.

“Полихлортбифенилийг байгаль орчинд ээлтэй аргаар устгах менежментийн чадавхыг бий болгох (GF/MON/09/001)” төслийн хүрээнд 110/35/10 кВ-ын Сэлбэ дэд станцын Т-1 трансформатор, 220/110/35 кВ-ын ИХБ-4 дэд станцын АТ-1 автотрансформаторын тусгаарлах эрдэс тосыг хатааж, ПХБ-ийн бохирдлыг цэвэрлэсэн.

Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд 110/10 кВ-ын хоёр шинэ дэд станц, 110 кВ-ын Баруун дэд станцын хүчин чадлыг 2х40 МВА болгох өргөтгөл шинэчлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

Компани, салбарын нэгдсэн агуулахыг тусгаарлах хана, хаалга хийж, Улаан тоосгон

складны хаалга цонхны битүүмжлэлийг хийж, хөрөнгийн хадгалалтыг сайжруулж цэгцэлсэн. (20 нэр төрлийн 120 гаруй тоног төхөөрөмж)

Сэлбэ дэд станцын барилгын засварын ажлыг бүрэн хийсэн.

Эрчим хүчний зохицуулах хороотой байгуулсан “Урамшуулалт зохицуулалтын гэрээ”-ний хэрэгжилтийг хангах, компанийн эрчим хүч хэмнэлтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, эрчим хүч хэмнэх, үр ашигтай хэрэглэхэд ажилтнуудын оролцоо, идэвх санаачилгыг өрнүүлж урамшуулан дэмжихэд “Дотоод хэрэгцээгээ үр ашигтай хэрэглэж, хэмнэлт гаргацгаая” болзолт уралдаанд оролцож, Улаанбаатар салбарын Яармаг дэд станцын хамт олон хоёрдугаар байрт шалгарсан.

“Компанийн аварга шалгаруулах спортын таван төрөлт тэмцээн-2018” тэмцээнийг Улаанбаатар хотноо зохион байгуулж, “Улаанбаатар салбарын хамт олон манлайлж, шилжин явах цомыг 3 дахь жилдээ дараалан гардаж, “Шилжин явах цом”-ыг үүрд хадгалсан.

2019 он

220/110 кВ-ын АТ-1,2-г зэрэгцээ ажиллагаанд залгаж дамжуулах чадварыг 125 МВА чадлаар нэмэгдүүлэх ажлыг богино хугацаанд амжилттай хийж гүйцэтгэсэн. 2010 онд АТ-2-г ажилд залгасан ч зэрэгцээ ажиллагаанд залгаж чадалгүй 9 жилийн хугацаа өнгөрсөн. Энэ ажилд инженерийн шийдэл гаргаж горим тооцоо хийж, богино хугацаанд тоноглолын угсралтыг хийн, реле хамгаалалтыг шинээр монтажлан тусдаа таслууртай, реле хамгаалалттай болгож, Эрчим хүчний системийн найдвартай ажиллагааг хангасан томоохон ажил болсон. АТ-1,2-г зэрэгцээ ажиллагаанд залгах ажлыг Улаанбаатар салбарын ажилтнууд өвлийн их ачааллаас өмнө хөдөлмөр хамгааллын зөрчилгүй богино хугацаанд хурдан шуурхай амжилттай хийж гүйцэтгэсэн.

Монгол Улсад анх удаа 110 кВ-ын ЦДАШ-ын схем холболтоос шалтгаалан 2,3,4 төгсгөлт хамгаалалтыг амжилттай нэвтрүүлсэн. Бага тойрог шугамын үндсэн хамгаалалтыг найдваржуулах ажлыг богино хугацаанд тасралт саатал гаргалгүй амжилттай гүйцэтгэсэн.

Нийслэлийн агаар, орчны бохирдлыг бууруулах ажлын хүрээнд халаалтаар шийдэх 41964 айл өрхийн 4 кВт

суурилагдсан хүчин чадалтай халаагуур, гэр хорооллын шөнийн тарифтай болсноор Улаанбаатар хотын цахилгаан эрчим хүчний хэрэглээ нэмэгдэх гол нөлөөг үзүүлж байна. Энэ ажлын хүрээнд Улаанхуаран дэд станцын Т-1, 2 трансформаторын хүчин чадлыг нэмэгдүүлэх, ПРП-110 дэд станцын Т1 трансформаторын хүчин чадлыг нэмэгдүүлж, 110 кВ-ын 2 секцтэй болгон өргөтгөж, схемийн найдвартай ажиллагааг дээшлүүлсэн.

Төвийн бүсийн нэгдсэн системийн цахилгаан эрчим хүчний хэрэглээ тасралтгүй өсөн нэмэгдэж байгаа өнөө үед цахилгаан эрчим хүчний тогтвортой найдвартай ажиллагааг хангах зорилгоор 107,108,109,110 дугаар ЦДАШ-ын дамжуулагч утсыг сольж, шугамын дамжуулах чадварыг 2 дахин нэмэгдүүлсэн. Энэ ажлын хүрээнд дамжуулах компанийн найдвартай ажиллагааг хангах, хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хязгаарлахгүйгээр инженерийн шийдлийг гаргаж, схемийн өөрчлөлт, холболт угсралтын ажлыг амжилттай хийж гүйцэтгэсэн.

Дэд станцуудыг категоричилсноор ажлын ачаалал, хариуцлага зэргээс хамаарч ээлжийн ажилтнуудын цалин адилхан байсанг салгаж өгсөн нь ололттой ажил болсон. Дээрх ажлыг хэрэгжүүлснээр цаашид ажилтнуудын ажлын идэвх зүтгэл сайжирсан.

Гурвалжингийн гүүрний баруун талд 110 кВ-ын 109,110 дугаар ЦДАШ-ын хамгаалалтын зурваст байрлан үйл ажиллагаа явуулж байгаа өргөх зөөх, том оврын машин механизмуудыг холдуулж, хамгаалалтын зурвасыг чөлөөлж, хашаа барих ажлыг 2019 оны 08 дугаар сарын 15, 27-ны өдрүүдэд зохион байгуулж, МҮОНРТ-ээр өндөр хүчдэлийн аюул эрсдэлийн талаар сурталчилсан. Дээр ажлын хүрээнд ЭХЯ, МХЕГ, ЦЕГ, төв удирдлагад удаа дараа танилцуулга материал бэлтгэж, дамжуулан хүргүүлсний үндсэн дээр дээрх ажил хийгдсэн.

Ажилтнуудын сахилга хариуцлага, цаг ашиглалтыг сайжруулах үүднээс бүх дэд станцуудад цаг бүртгэлийн төхөөрөмж суурилуулж, хүний оролцоогүйгээр ажилтнуудын цагийг бүртгэж хянадаг болсон.



2025 ОНЫ 1-Р САРЫН 1-НЭЭС ХЭРЭГЖИЖ ЭХЛЭХ ХУУЛЬ ЖУРМУУДЫГ ТАНИЛЦУУЛЖ БАЙНА

Тэтгэврийн хэмжээг **6 ХУВИАР** нэмэгдүүлнэ.
Төрийн албан хаагчдын цалинг **6 ХУВИАР** нэмэгдүүлнэ.
Төрийн албан хэргийг кирилл болон **ҮНДЭСНИЙ** бичгээр хөтөлнө.
Автобусаар зорчихдоо **1000 ТӨГРӨГ** болно.
Зэвсэгт хүчин, хилийн цэргийн онцгой нөхцөлийн нэмэгдлийг **10-25 ХУВЬ** болголоо.
Одонтой эхэд олгодог мөнгө тусламжийн хэмжээ **2 ДАХИН** нэмэгдпээ.
Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг **792 МЯНГА ТӨГРӨГ** болгов.
Ахмад настны тэтгэвэр, тэтгэмжийг зөвшөөрөлгүй зарцуулбал **ХОРИХ ЯЛ ОНООНО**.
Автомашину **АЛБАН ТАТВАР** нэмэгдэнэ.

Үргэлжлэлийг дараагийн дугаарт

Эрхлэн гаргасан: Захиргаа
удирдлагын хэлтэс